



**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

Багахангай дүүргийн авто замын ус  
зайлуулах байгууламжийн ажлын гүйцэтгэгчийг  
сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/878 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийн авто замын ус зайлуулах байгууламжийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Д.Хүрэлбаатар	Засаг даргын Тамгын газрын Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
Гишүүд:	Ж.Наранцэцэг	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Захиргааны зохион байгуулалт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хороо хариуцсан мэргэжилтэн
	Б.Хишиг-Ундрал	Багахангайн тохижилт ОНӨААТҮГ-ын инженер
	П.Бор	2 дугаар хорооны иргэн
Нарийн бичиг	Д.Ганчимэг	Худалдан авах ажиллагааны албаны Санхүү, сургалт, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн

2.Хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо (Д.Хүрэлбаатар)-нд даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа) -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД